



International Organization for Migration (IOM)

The UN Migration Agency

DTM

ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙГ ТАНДАХ – МОНГОЛ УЛС ДАХЬ ГАМШГИЙН БЭЛЭН БАЙДАЛ СУУРЬ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН: УВС АЙМАГ

1-Р ШАТ 2018 ОН



УВС АЙМАГ СУУРЬ ҮНЭЛГЭЭ

2018 ОНЫ 1-3 САР

ОРШИЛ

Монголчууд эртнээс нааш урт, богино хугацаагаар нүүж, шилжиж, хөдөлгөөнтэй амьдарч ирсэн уламжлалтай. Тиймдээ ч, богино хугацааны (< 3 сараас) шилжилт хөдөлгөөний талаарх мэдээллийг системтэй байдлаар цуглуулдаггүй. Гэвч, сүүлийн үед Улаанбаатар руу чиглэсэн шилжилт нэмэгдэж байгаа нь уур амьсгалын өөрчлөлт зэрэг хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалж байгаа бөгөөд үүнд эрүүл мэнд, боловсролын сайн үйлчилгээ хүртэх, ажил эрхлэлтийн илүү сайн боломж нөхцөлтэй болох хүсэл, шалтгаан голлож байна.¹

Монгол орон газар зүйн өвөрмөц байршилтай, хөдөөгийн хүн ам нь мал аж ахуйн салбараас ихээхэн хамааралтай байдаг зэргээс уур амьсгалын өөрчлөлт, өвөл цагийн хүндрэлд өртөмтгий байдаг. Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалан ган, зуд² ын давтамж нэмэгдснээс хөдөөгүүр хүмүүсийн амьжиргаа залгуулах боломж хомсдож орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн ихсэх хандлагатай байна.

Хэрэв энэ хандлага үргэлжилсээр байвал, давтамж нь өсөн нэмэгдэж буй гамшгийн нөлөөгөөр орон нутгаас Улаанбаатарыг зорих шилжин суурьшигчийн тоо эрчимтэйгээр өсөн нэмэгдэнэ. Нийслэлийн захиргаа шинээр ирж буй шилжин суурьшигчийг байршуулж суурьшуулахад ихээхэн бэрхшээлтэй тулгарсаар байна. Гамшгийн бэлэн байдлыг хангах, онцгой байдлын үед зорилтот хариу арга хэмжээ авах зорилгоор Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ) нь тухайн газар дээр байгаа хүний тоог мэдэх ба хүн амын шилжилт хөдөлгөөний талаархи тодорхой мэдээлэл авах шаардлагатай байгаа юм.

Тус оронд гамшигт үзэгдэл нэмэгдэж байгааг үндэслэн Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага (ОУШХБ), Монгол Улс дахь гамшгийн бэлэн байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор шилжилт хөдөлгөөнийг тандах цогц мэдээллийн системийг бий болгох ажлыг эхлүүлсэн.

Энэхүү системийг нэвтрүүлэхдээ уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шилжилт хөдөлгөөний талаар Шилжин суурьшилтын нөхцөл байдлын үнэлгээ (ШСБНҮ) хийх аргаар мэдээллийг цуглуулж боловсруулан, гамшгийн бэлэн байдлыг хангах, онцгой байдал үүссэн үед хэрэглэх боломж бүхий мэдээллийн сан үүсгэж байна.

¹ Монгол Улсын Их Сургууль (МУИС), Нэгдсэн Үндэсний Байгууллагын Их Сургууль – Мерит болон Олон Улсын Шилжих Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ) (2018 он). “Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөнийг ойлгож зохицуулах нь.”

² Зуд гэдэг нь Монгол Улсад тохиолддог өвөрмөц, удаан хугацаагаар үргэлжилдэг улирлын чанартай байгалийн гамшиг юм. Энэ нь зундаа ган болсны дараа өвөл,, хаврын улиралд цаг агаарын нөхцөл байдал эрс доройтож, ус, бэлчээрийн дутагдал гарч их хэмжээний малын хорголдол хүргэхийг хэлнэ

ШСБНҮ нь шилжин суурьшиж буй хүн амын богино хугацааны нүүдэл, шилжин суурьшилтын талаарх мэдээллийг цуглуулж, боловсруулж байгаагаараа онцлог юм.

АРГАЧЛАЛ

ОБЕГ-аас хэрэгжүүлэх мэдээлэл цуглуулах арга хэрэгсэл, стратеги нь ШСБНҮ-ийн дэлхийн аргачлал дээр тулгуурласан бөгөөд Монголын нөхцөл байдал, шилжин суурьшилтийн хэв маягт тохирсон юм. Цуглуулсан мэдээллийн өөр өөр түвшин нь Монгол улсын хүн амын цогц дүр төрхийг харуулахад хувь нэмрээ оруулна.

Энэхүү суурь үнэлгээнд ОУШХБ нь хүн амыг шилжин суурьшилтийн төрхөөр нь хоёр бүлэгт ялгадаг: оршин суугчид (тухайн байршил/газарт амьдарч буй аливаа хүн), шилжин суугч хүн ам (1-3 сарын дотор сумаас гарсан/сум руу шилжин ирсэн хүмүүс).

ОБЕГ, ОУШХБ - ын тодорхойлолтоор шилжин суугч гэдэг нь хэн нэгэн өөрийн хүслээр эсвэл ямар нэгэн гадны хүчин зүйлээс шалтгаалан нэг газраас нөгөө газар руу түр хугацаагаар, улирлын хугацаагаар, эсвэл бүрмөсөн шилжин суурьшихыг хэлнэ. Энэ нь малчдын богино хугацааны нүүдлээс эхлэн иргэдийн урт хугацаагаар, бүрмөсөн шилжин суух зэрэг шилжих хөдөлгөөний бүх хэлбэрийг хамарна.

Байршлын үнэлгээг нийслэл Улаанбаатарыг оролцуулалгүйгээр засаг захиргааны хоёрдахь шатны түвшинд (сум) явуулсан. ОУШХБ-тай зөвлөлдсөний үндсэн дээр ОБЕГ-аас олж тодорхойлсон гол мэдээлэгчтэй ярилцлага хийж, тухайн орон нутгийн хүн амын багцаа тоо, нүүж ирсэн болон нүүж явсан иргэдийн тоо, хөдөлгөөнд оролцсон сар, хаанаас хаашаа ямар шалтгаанаар нүүсэн талаар мэдээлэл цуглуулсан.


Энэхүү үнэлгээг 330 гаруй сумдад (Улаанбаатар ороогоүй) явуулсан. Энэхүү тайланд зөвхөн Увс аймаг дахь хүн амын шилжих хөдөлгөөнд хийсэн дүн шинжилгээг танилцуулна.



ТОВЧ ТОЙМ

Увс аймаг нь Монгол Улсын 21 аймгийн нэг юм. Тус аймаг нь улсын баруун хязгаарт, Улаанбаатар хотоос 1,336 километрын зайд байрладаг. Аймгийн төв нь далайн түвшнээс 936 м дээш оршдог Улаангом хот юм. Тус аймаг Монголын хамгийн том нуур болох Увс нуурын нэрээр нэрлэгдсэн юм. Тус аймаг улсын газар нутгийн 4.45 хувь буюу 69,585 км² эзэлдэг. Гол салбар нь хөдөө аж ахуй буюу мал аж ахуй ба газар тариалан.

Нийт аймгийн газар нутгийн 60 хувь нь уулын цаг уурын бүсэд хамаардаг бол 40 хувь нь говийн хагас цөлийн бүсэд ордог



Агаарын хамгийн дээд температур 7-р сард +40-50°C, хамгийн бага нь 1-р сард -40-50°C хүрдэг
Засаг захиргааны хувьд тус аймаг 19 сумд хуваагддаг.

ГОЛ ДҮГНЭЛТ

Увс аймагт ажиглагдсан хүн амын шилжилт хөдөлгөөн энэхүү чиг хандлага үргэлжилсээр байгаа бөгөөд цаг агаарын хүнд нөхцөл байдлын улмаас сумдаас өөр сум руу нүүж шилжих хөдөлгөөн нэмэгдсэн байна гэдгийг харуулж байна.

Олонхи хүн (Увс аймгаас 2018 оны 1-3 сард нүүж явсан нийт хүний 63 орчим хувь нь) гурван сумаас нүүсэн байна: Завхан, Улаангом, Зүүнхангай.

Үнэлгээний хугацаанд тухайн иргэний нүүж явсан сумаас хамааран явсан цаг, очих газрын хувьд зарим зөрүү ажиглагдлаа.

Завхан сумаас нүүсэн бүх иргэд 1-р сард Ховд аймгийн Мянгад сум руу нүүж явсан. Зүүнхангай сумаас нүүж явсан иргэдийн 90 хувь нь 2-р сард нүүсэн, бүгд Улаанбаатар руу явсан байна.

Зүүнхангай сумаас нүүж явсан иргэд ихэвчлэн эдийн засгийн шалтгаанаар Улаанбаатар хот руу илүү сайн эдийн засгийн нөхцөл хайж явсан, харин Завхан сумаас 1-р сард Ховд аймгийн Мянгад сум руу нүүсэн иргэдийн хөдөлгөөн ихэвчлэн өвөлжилт хүндэрсэн нөхцөл байдалтай холбоотой.



ХЭДЭН ХҮН ХААНААС НҮҮСЭН БЭ?


2018 оны 1-3 сарын хооронд нийт 673 иргэд Увс аймгаас нүүж явсан байна.

Нүүж явсан иргэдийн тоо сумаас хамааран ихээхэн хэлбэлзэж байна. Увс аймгаас нүүж явсан нийт иргэдийн 63% нь гурван сумаас нүүж явсан: Завхан, Улаангом, Зүүнхангай.


Хамгийн бага нүүсэн иргэдийн тоо нь Цагаанхайрхан ба Өлгий сумд гарлаа.

Доорх газрын зураг дээр Увс аймгаас нүүж явсан иргэдийн тоог сумаар харуулж байна.

Зураг 1: Увс аймгаас 2018 оны 3-1 сард нүүж явсан иргэдийн тоо, сумаар.



Газрын зураг 1: Увс аймгаас 2018 оны 3-1 сард нүүж явсан иргэдийн тоо, сумаар.



ИРГЭД ХААШАА ЯВСАН БЭ?

Нийт иргэдийн тал орчим хувь нь байнга оршин суудаг сумаасаа Увс аймгийн өөр сум руу нүүсэн байна.

Очих газар нь 2018 оны 1-3 сарын хооронд нилээд хэлбэлзэж байв. 1-2 сард Увс аймгийн өөр сум руу нүүсэн иргэдийн хувь мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй бол, 3-р сард энэ хувь хэмжээ нь 2-р сартай харьцуулахад өссөн байна.


Зураг 2: Увс аймгаас 2018 оны 3-1 сард нийслэл хот/өөр аймаг/Увс аймгийн өөр сум руу нүүж явсан иргэдийн хувь.



Увс аймгаас 1-р сард нүүсэн нийт иргэдийн тал орчим хувь нь өөр аймаг руу (ихэвчлэн Завхан сумаас Ховд аймгийн Мянгад сум руу) нүүж явсан бол, үлдсэн тал нь Увс аймгийн өөр сум руу нүүсэн байна. Өөр аймаг руу нүүсэн иргэдийн хувь 1-р сард 54 хувь байснаас 2-р сард 4 хувь, 3-р сард 9 хувь хүртэл тус тус буурсан.

2-р сард нийслэл Улаанбаатар руу нүүх иргэдийн тоо нэмэгдсэн (ихэвчлэн Зүүнхангай сумаас).

Зураг 3: Увс аймгаас 2018 оны 3-1 сард нийслэл хот/өөр аймаг/Увс аймгийн өөр сум руу нүүж явсан иргэдийн хувь, сараар.




ИРГЭД ХЭЗЭЭ НҮҮЖ ЯВСАН БЭ?

Нийт нүүж явсан иргэдийн 56 хувь нь 1-р сард, 28 хувь 2-р сард, 16 хувь нь 3-р сард нүүсэн байна.

Харин өөр өөр сумд нүүсэн сар нь бага зэрэг хэлбэлзэлж байлаа.


Зураг 4: Увс аймгаас нүүж явсан of individuals иргэдийн хувь, сараар.




Завхан сумаас Ховд аймгийн Мянгад сум руу нүүсэн бүх иргэд 1-р сард явсан. Зүүнхангай сумаас нүүсэн иргэдийн 90 орчим хувь нь 2-р сард нүүсэн ба бүгд Улаанбаатар руу явсан байна.

Улаангом сумаас нүүж явсан иргэдийн очих газар сар сараар хэлбэлзэж байв. 1-р сард ихэнх нь Наранбулаг сум руу, 2-р сард Зүүнговь руу, 3-р сард Сагил сум тус тус нүүж явсан.

Зураг 5: Завхан, Улаангом, Зүүнхангай сумаас нүүсэн иргэдийн хувь, сараар.



Газрын зураг 2: Завхан, Улаангом, Зүүнхангай сумаас нүүсэн иргэдийн очих сум



НҮҮХ БОЛСОН ШАЛТГААН

Зүүнхангай сумаас нүүж явсан иргэд ихэвчлэн эдийн засгийн шалтгаанаар Улаанбаатар хот руу илүү сайн эдийн засгийн нөхцөл хайж явсан, харин Завхан сумаас 1-р сард Ховд аймгийн Мянгад сум руу нүүсэн иргэдийн хөдөлгөөн ихэвчлэн өвөлжилт хүндэрсэн нөхцөл байдалтай холбоотой.

1-р сард агаарын температур $-40-50^{\circ}\text{C}$ хүрдэг тул тус аймаг зудын эрсдэлд өртөх магадлалтай болдог. Доорх Монгол орны цасан бүрхэцийн зураг нь Ховд сумд Завхан сумтай харьцуулахад цас харьцангуй бага байгааг харуулж байна.

Газрын зураг 3: Монгол орны цасан бүрхэцийн зураг (2018 оны -1р сард).

